

ДОТООДЫН ЦЭРГИЙН 05 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ,
ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ НАРЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 05 дугаар сарын 21 өдөр Дугаар А/26, А/34

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дотоодын цэргийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.4 дэх заалтууд, Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (код 132)-ын 132.5.2-ын "г" заалт, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвд хүн, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйл, бараа материал шалган нэвтрүүлэх журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоодын цэргийн 05 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга (дэд хурандаа Д.Отгонбаатар), Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захиргааны албаны дарга (У.Нямжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Дотоодын цэргийн 05 дугаар ангийн захирагч, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал нарын хамтарсан А/100, А/50 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДОТООДЫН ЦЭРГИЙН 05 ДУГААР
АНГИЙН ЗАХИРАГЧ,
ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ

Б.АМГАЛАНБАЯР

ТТ35150-9092005

Дотоодын цэргийн 05 дугаар ангийн захирагч,
Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал
нарын хамтарсан 2015 оны 05 дүгээр сарын 21 -ны
өдрийн 1/86 тушаалын хавсралт

ТТ35150 9092005

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, АЧАА ТЭЭШ, ЭД ЗҮЙЛ, БАРАА МАТЕРИАЛ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Улсын онц чухал объект болох Зоонозын өвчин судлалын үндэсний төв, (цаашид "объект" гэх) түүний нутаг дэвсгэрт хүн, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйл, бараа материалыг шалган нэвтрүүлэх (оруулах, гаргах)-д энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Энэхүү журмын зорилго нь объектын хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ачаа тээш, эд зүйл, бараа материалыг оруулах, гаргах үед зохих зөвшөөрлийн баримт бичгийг үндэслэн шалган нэвтрүүлэх, бүртгэх, объектын захиргаанаас тогтоосон дэглэм, журмын хэрэгжилтийг хангахад оршино.

1.3. Журмыг объектын бүх ажилтан, албан хаагчид болон зөвшөөрлийн дагуу нэвтрэх гадны иргэн, гадаадын иргэд нэгэн адил дагаж мөрдөнө.

ХОЁР. ОБЪЕКТОД НЭВТРЭХ ҮНЭМЛЭХИЙН АНГИЛАЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ, ХЭРЭГЛЭХ, ХАДГАЛАХ

2.1. Объектын үндсэн ажилтан, албан хаагчид байнгын үнэмлэх эсвэл ухаалаг нэвтрүүлэлтийн систем таньсан тохиолдолд, тодорхой хугацаагаар болон гаднаас нэвтрэх иргэдийг иргэний үнэмлэх (гадаад паспорт, e-mongolia, жолоочийн үнэмлэх)-ийг зохих зөвшөөрөлтэй тулгаж объектод нэвтрүүлнэ.

2.2. Ажилтан, албан хаагчдын үнэмлэхийг объектын захиргаанаас олгоно.

2.3. Гадаадын иргэнийг объектод нэвтрүүлэхдээ гадаад паспорт, Монгол Улсад зорчих визний хүчинтэй хугацаа, холбогдох баримт бичгийг шалгаж, зөвшөөрлийг үндэслэн шалган нэвтрүүлж, объектод орсон, гарсан тухай бүртгэл хөтөлнө. Бичиг, баримтын зөрчилтэй болон "J" ангилал (жуулчин)-ын визтэй гадаадын иргэдийг объектод нэвтрүүлэхийг хориглоно.

2.4. Объектод оруулах, объектоос гаргах ачаа, тээш, эд зүйл, бараа материалын тоо хэмжээг зөвшөөрлийн хуудастай тулган шалган нэвтрүүлэгч хамгаалалтын ажилтан шалгаж, зөвшөөрлийн хуудсыг хураан авч, бүртгэлд бүртгэнэ.

ГУРАВ. ОБЪЕКТОД ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ БОЛОН АЧАА ТЭЭШ, ЭД ЗҮЙЛ, БАРАА МАТЕРИАЛЫГ ОРУУЛАХ ГАРГАХ

3.1. Объектод гаднаас нэвтрэх ажилтан, албан хаагчид, иргэд (тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйл, бараа материал)-ийг зөвхөн шалган нэвтрүүлэх 1 дүгээр цэгээр шалган нэвтрүүлнэ.

3.2. Объектод сургалт, дадлага болон бусад шалтгаанаар нэвтрэх иргэд, тээврийн хэрэгслийг зөвхөн хүний нөөцийн ажилтны зөвшөөрөл, холбогдох баримт бичгийн хамт салбарын хамгаалалтын офицер урьдчилан хүргүүлж мэдэгдсэнээр шалган нэвтрүүлнэ.

3.3. Объектод бараа материалыг нэвтрүүлэх, гаргах, дамжин өнгөрүүлэх тохиолдолд зөвхөн Санхүү, хангамж, нөөцийн албаны даргын зөвшөөрөл, холбогдох баримт бичгийн хамт салбарын хамгаалалтын офицер урьдчилан хүргүүлж мэдэгдсэнээр шалган нэвтрүүлнэ.

3.4. Объектод сургалт, дадлага, тусгай арга хэмжээнд уригдах, тусгай үйл ажиллагаанд оролцох 16 наснаас доош насны хүүхэд болон бусад шалтгаанаар нэвтрэх иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргаж тухай бүрт нь салбарын захирагчид бичгээр хүргүүлэх ба тухайн иргэдийг нэвтрүүлэхдээ иргэний үнэмлэх (төрсний гэрчилгээ, гадаад паспорт, e-mongolia, жолоочийн үнэмлэхийн)-ийг шалган жагсаалтад тусгагдсан нэрстэй тулгаж нэвтрүүлнэ.

3.5. Хүний нөөцийн менежер нь ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн иргэдийн мэдээллийг тухай бүрт нь салбарын захирагчид бичгээр мэдэгдэнэ.

3.6. Түр хугацаагаар (зөвхөн ажлын цагаар 1 удаа орох, гарах) нэвтрэх гадаадын иргэнийг объектын захиргаанаас аль улсын харьяат иргэн, ямар зорилгоор, хаана, ямар хугацаатай ажиллах талаар албан ёсоор мэдэгдэж, баримт бичгийн хуулбарыг анги, салбарын захирагчид өгсний дараа хамгаалалтын офицер Дотоодын цэргийн үйл ажиллагааны "Улсын онц чухал объектод гадаадын иргэн нэвтрүүлэх, хяналт тавих, хамтран ажиллах (код 1211) журам"-д заасны дагуу түр зөвшөөрлөөр нэвтрүүлнэ.

3.7. Объектод 2 буюу түүнээс дээш хоногоор албан ажлаар нэвтрэх гадаадын иргэнийг нэвтрүүлэх талаар объектын захиргаанаас ирүүлсэн хүсэлт, холбогдох материал (албан бичиг, паспорт болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон түр оршин суух үнэмлэх, визийн хуулбар)-ын хамтаар Дотоодын цэргийн штабт 7-10 хоногийн өмнө урьдчилан хүргүүлж, зөвшөөрөл авснаар нэвтрүүлэх ба дээрх бичиг баримтыг хугацаанд нь хүргүүлээгүйн улмаас үүссэн асуудлыг хамгаалагч тал хариуцахгүй болно.

3.8. Объектын хашаанд зөвхөн объектын захирлын баталсан жагсаалтад орсон тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх ба нэвтрэх ажилтны нэр, албан тушаал, автомашины марк, улсын дугаар бүхий жагсаалтыг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор салбарт гаргаж өгөх бөгөөд жагсаалтын дагуу шалган нэвтрүүлнэ. Жагсаалтад өөрчлөлт оруулсан тохиолдолд тухай бүрт нь шинэчлэгдсэн зөвшөөрлийн хуудсыг хамгалалтын салбарт ирүүлнэ. Шалган нэвтрүүлэх журам зөрчсөн ажилтан, албан хаагчдын тээврийн хэрэгслийг объектын бүсэд нэвтрүүлэхгүй.

3.9. Ажлын бус цагаар яаралтай ирсэн мал, амьтан (мэрэгч), амьтны гаралтай түүхий эд, бусад материал (ийлдэс, сорьц)-ыг дуудлага хяналтын жижүүрийн бага эмчийг дуудан шинжилгээний материал авчирсан хүний баримт

бичиг, утасны дугаарыг тэмдэглэн авч, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслийг сайтар шалгаж нэвтрүүлнэ.

3.10. Объектод нэвтрэхээр ирсэн гадны иргэний тээврийн хэрэгслийг объектын гадна зогсоолд байрлуулах бөгөөд овор ихтэй бараа материал нэвтрүүлэх шаардлагатай тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх 1 дүгээр цэгээр объектын захирлын зөвшөөрлийн бичгээр нэвтрүүлнэ. Гадны объектын емч болох ажил гүйцэтгэхэд ашиглах эд зүйл, бараа материал, багаж хэрэгслийг нэвтрүүлэхэд объектын захиргаанаас оруулах, гаргахыг хүссэн зөвшөөрөл бүхий албан бичгийг үндэслэн шалган нэвтрүүлнэ. Баримтад тусгаагүй эд зүйлс, багаж хэрэгсэл, бараа материалыг оруулах, гаргахыг хориглоно.

3.11. Объектод гаднаас нэвтрэх иргэний авч орох бараа, материал, бусад зүйлсийг объектын захирлын зөвшөөрөл, жагсаалттай тулгаж шалган нэвтрүүлэх 1 дүгээр цэгээр нэвтрүүлж, гаргана.

ДӨРӨВ. ОБЪЕКТЫН ЗАХИРГААНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

4.1. Объектын үндсэн ажилтан, албан хаагчдад байнгын үнэмлэхийг объектын захиргаа олгоно.

4.2. Объектын үндсэн болон сургалт, дадлага бусад шалтгаанаар нэвтрэх иргэдийн талаарх холбогдох мэдээллийн хүснэгтийг хамгаалагч талаас гаргаж, хүснэгтийн дагуу тухай бүрт нь шинэчлэн гаргаж өгнө.

4.3. Ажлаас халагдсан иргэн болон сургалт, дадлага бусад шалтгаанаар нэвтрэх эрхийн хугацаа дууссан иргэн, аж ахуй нэгжийн талаарх мэдээллийг шинэчлэн, салбарт тухай бүрт нь бичгээр мэдэгдэнэ.

4.4. Объектод нэвтрэх зөвшөөрөл бүхий албаны болон хувийн тээврийн хэрэгслийн жагсаалт (жолоочийн нэр, улсын дугаар, автомашины марк)-ыг объектын захиргаанаас салбарт энэ журмын 3.8 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр өгнө.

4.5. Баяр, амралтын өдрүүдэд ажиллах зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчид (ээлжийн ажилтнаас бусад)-ын нэрсийг объектын захиргаанаас урьдчилан салбарт гаргаж өгөх бөгөөд зөвшөөрлийн бичгийг үндэслэн шалган нэвтрүүлнэ.

4.6. Объектод нэвтэрсэн гадны иргэд объектын дотоод журам, эрүүл ахуй, ариун цэвэр, хорио цээрийн дэглэмийг чанд сахин биелүүлэх үүрэгтэй ба объектын холбогдох албан тушаалтан түүнд хяналт тавина.

4.7. Шалган нэвтрүүлэх ажиллагааны явцад зөрчил гаргасан ажилтан, албан хаагчдыг салбарын зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох бөгөөд объектын захиргаанд танилцуулан, тухайн ажилтан, албан хаагчдад хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага тооцож, хариуг 14 хоногийн дотор салбарын захирагчид бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. ШАЛГАН НЭВТРҮҮЛЭГЧ ХАМГААЛАЛТЫН АЖИЛТНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

5.1. Объектод нэвтэрч байгаа үндсэн ажилтан, албан хаагчдын ажлын үнэмлэх, гаднаас нэвтрэх иргэдийн иргэний үнэмлэх (гадаад паспорт, e-mongolia, жолоочийн үнэмлэх)-ийг үндэслэн шалгаж, нэвтрүүлнэ.

5.2. Объектод явганаар нэвтрэн орж, гарч байгаа ажилтан, албан хаагч, иргэдийн цүнх, сав, баглаатай эд зүйлсийг шалгаж үзэх ба шаардлагатай бол Дотоодын цэргийн тухай хуулийн 33.1.1 дэх заалтыг үндэслэж гар цүнх, биед үзлэг хийнэ.

5.3. Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдийг Дотоодын цэргийн тухай хуулийн 33.1.2 дахь заалтыг үндэслэн шалган саатуулж, шаардлагатай тохиолдолд харьяа дүүргийн цагдаагийн байгууллагад шилжүүлж, энэ тухай объектын захиргаанд мэдэгдэнэ.

5.4. Объектод зөвхөн зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх ба ачаа тээш, эд зүйл, бараа материалыг дагалдах баримт бичиг, зөвшөөрлийн бичигтэй нь тулган шалгаж үзнэ. Тээврийн хэрэгсэлд яваа бусад иргэнийг машинаас буулгаж явганаар шалгаж нэвтрүүлнэ.

5.5. Объектод нэвтэрсэн гадны иргэд, тээврийн хэрэгсэл, бараа материалыг шалган нэвтрүүлэх бүртгэлд бүртгэнэ.

5.6. Шалган нэвтрүүлэх цэгээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийг бүрэн зогсолт хийсний дараа жолоочийг байлцуулан тээврийн хэрэгслийг жолоочоор нээлгүүлэн тээврийн хэрэгсэлд үзлэг хийх ба шаардлагатай бол тээврийн хэрэгсэл доторх цүнх, сав баглаа, боодлыг жолоочоор нээлгүүлэн бүрэн шалгалт хийнэ.

5.7. Объектод хүн, тээврийн хэрэгсэл, ачаа, тээш, эд зүйл, бараа материалыг шалгах явцад илэрсэн зөрчил дутагдал, зөрчил гаргасан этгээдийн талаар хамгаалалтын офицер тухай бүрт нь мэдэгдэх ба хамгаалалтын офицер салбарын захирагч, объектын захиргаанд танилцуулна.

ЗУРГАА. ОБЪЕКТОД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ҮЕД ТҮРГЭН ТУСЛАМЖ, ГАЛЫН БОЛОН ОСЛЫН ДУУДЛАГААР ИРСЭН АВТОМАШИНЫГ НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

6.1. Үйлдвэрлэлийн осол, гал түймэр, байгалийн гамшиг, бусад болзошгүй эрсдэл тохиолдсон үед хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, шалган нэвтрүүлэх ажиллагааг чангатгана.

6.2. Объектод үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан үед түргэн тусламж, галын болон ослын дуудлагаар ирсэн хүн, тээврийн хэрэгслийг саадгүй нэвтрүүлнэ.

ДОЛОО. ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ҮЕД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

7.1. Баяр, амралтын өдөр болон ажлын бус цагаар объектын захиргааны зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл болон ачаа тээш, эд зүйл, бараа материал оруулах, гаргахыг;

7.2. Объектод 16 наснаас доош насны хүүхэд (тусгай арга хэмжээнд уригдах, тусгай үйл ажиллагаанд оролцохоос бусад тохиолдолд) оруулахыг;

7.3. Объектод архи согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэсэн хүн нэвтрүүлэхийг;

7.4. Объектод архи согтууруулах ундаа, тэсэрч дэлбэрэх бодис, химийн хорт бодис, галт зэвсэг болон сум, хутга мэс, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл авч орохыг;

7.5. Шалган нэвтрүүлэх цэгээр объектод зөвшөөрөлгүй худалдаа наймаа хийх зорилгоор эд зүйл авч орохыг;

7.6. Нэг удаагийн зөвшөөрлөөр нэвтэрсэн иргэн зөвхөн уулзах хүнтэйгээ уулзаад гарах ба объектын бусад хэсгээр явахыг;

7.7. Объектод эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйл, бараа материал оруулах, гаргахыг;

7.8. Объектод нэвтрэх зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгслийн жагсаалтад ороогүй болон зохих зөвшөөрлийн бичиггүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхийг тус тус хориглоно;

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1. Шалган нэвтрүүлэх журам зөрчсөн, зөрчил үйлдсэн ажилтан, албан хаагчдын үнэмлэхийг хураан авч, объектын захиргаанд мэдэгдэнэ.

8.2. Шалган нэвтрүүлэх журам зөрчсөн, зөрчил үйлдсэн ажилтан, албан хаагчид, иргэний үйлдсэн зөрчлийг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд шалгаж шийдвэрлэх, шаардлагатай бол харьяа дүүргийн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шилжүүлж шийдвэрлэнэ.

8.3. Шалган нэвтрүүлэгч хамгаалалтын ажилтан албан үүргээ гүйцэтгэх үедээ энэ журмыг зөрчсөн нь албаны шалгалтаар тогтоогдвол холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.4. Харуулын албан үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид Цэргийн дотоод албаны дүрэм, Дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн дагуу объектын ажилтан, албан хаагчид, иргэнтэй зөв боловсон харьцана.

8.4. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.